



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/247

Булган сум

“Дэлхийн адууны өдөр” арга хэмжээний морин парадад оролцох, бэлтгэл ажил хангах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 26 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Нүүдэлчин ахуй, ёс заншлыг хадгалан хамгаалах, адууны өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах “Дэлхийн адууны өдөр” арга хэмжээний морин парадад оролцох, бэлтгэл ажил хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Морин парадын бэлтгэл ажлын талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг сар бүрийн 05-ны өдрийн дотор морин парад хариуцсан ажлын хэсгийн дарга Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал Д.Ганхуягт хүргүүлж ажиллахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т үүрэг болгосугай.

3. Бэлтгэл ажлыг чанартай хангаж, нэгдсэн зохион байгуулалттай оролцохыг ажлын хэсэг (О.Ундрах), малчид, уяачдыг холбож, хамтарч ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

Д. ПУРЭВ-ОЧИР



6326010334

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 08-ныгний өдрийн
А.ДНД дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: Г.Гантулга (Аймгийн Засаг даргын тамгын газрын
Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч)
Б.Ариунболд (Аймгийн Засаг даргын тамгын
газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Э.Эрболд (Аймгийн Засаг даргын тамгын газрын
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны
дарга)
Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
дарга)
Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга,
хурандаа)
Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга, дэд
хурандаа)
Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)
Г.Оюунзаяа (Хүүхэд, гэр бүлийн хөгжил,
хамгааллын газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч)
Б.Гүндсамбуу (Морин спорт уяачдын холбооны
тэргүүн)
А.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж
ахуйн ахлах мэргэжилтэн)
Сумын Засаг дарга нар
Нарийн бичгийн дарга: М.Жавзандолгор (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
Мал аж ахуйн хэлтсийн дарга)

--o00o--